210203	ҮОМШӨ-ний даатгал	2,908,300.00	2,555,897.57	2,555,897.57	0.00
210204	Ажилгүйдлийн даатгал	723,800.00	604,551.86	604,551.86	0.00
210205	Эрүүл мэндийн даатгал	7,237,100.00	6,128,666.72	6,128,666.72	0.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	341,965,000.00	341,423,737.00	302,480,037.00	39,912,700.00
210301	Гэрэл, цахилгаан	20,077,900.00	17,299,344.00	17,299,344.00	0.00
210302	Түлш, халаалт	319,092,100.00	321,439,393.00	321,439,393.00	0.00
210303	Цэвэр, бохир ус	2,795,000.00	2,685,000.00	2,685,000.00	969,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	45,582,000.00	40,888,995.00	40,888,995.00	0.00
210401	Бичиг хэрэг	2,800,100.00	2,799,850.00	2,799,850.00	0.00
210402	Тээвэр, шатахуун	26,304,400.00	26,302,305.00	26,302,305.00	0.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	7,030,000.00	4,827,690.00	4,827,690.00	0.00
210404	Ном, хэвлэл	792,000.00	644,800.00	644,800.00	0.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	5,600,000.00	3,381,850.00	3,381,850.00	0.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	3,055,500.00	2,932,500.00	2,932,500.00	0.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	49,965,000.00	48,208,900.00	46,708,900.00	6,913,000.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	6,120,000.00	6,120,000.00	6,120,000.00	0.00
210604	Урсгал засвар	43,845,000.00	42,088,900.00	42,088,900.00	5,413,000.00
2107	Томилолт, зочны зардал	11,600,000.00	9,318,000.00	9,318,000.00	0.00
210702	Дотоод албан томилолт	11,600,000.00	9,318,000.00	9,318,000.00	0.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	145,338,000.00	143,560,760.00	143,560,760.00	15,503,000.00

Есөнзүйл сумын төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	136,188,000.00	135,077,747.00	135,077,747.00	15,503,000.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	1,000,000.00	576,000.00	576,000.00	0.00
210803	Даатгалын үйлчилгээ	200,000.00	113,850.00	113,850.00	0.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	750,000.00	656,163.00	656,163.00	0.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	140,000.00	77,000.00	77,000.00	0.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	6,750,000.00	6,750,000.00	6,750,000.00	0.00
210807	Газрын төлбөр	310,000.00	310,000.00	310,000.00	0.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	230,071,000.00	199,379,400.00	131,971,000.00	89,068,900.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	222,911,000.00	193,719,400.00	193,719,400.00	21,660,500.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	7,160,000.00	5,660,000.00	5,660,000.00	0.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	97,882,800.00	94,211,357.00	94,211,357.00	0.00
2131	Засгийн газрын урсгал шилжүүлэг	33,000,000.00	33,000,000.00	33,000,000.00	0.00
213101	Засгийн газрын дотоод шилжүүлэг	33,000,000.00	33,000,000.00	33,000,000.00	0.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	64,882,800.00	61,211,357.00	61,211,357.00	0.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	24,711,700.00	24,711,700.00	24,711,700.00	0.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	39,636,100.00	35,964,657.00	35,964,657.00	0.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	535,000.00	535,000.00	535,000.00	0.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	341,124,900.00	160,870,000.00	160,870,000.00	50,000,000.00
223001	Бусад хөрөнгө	341,124,900.00	160,870,000.00	160,870,000.00	50,000,000.00
23	ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ	239,975,000.00	174,347,850.00	0.00	174,347,850.00
230001	Эргэж төлөгдөх зээл	239,975,000.00	174,347,850.00	174,347,850.00	0.00
III	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	1,912,437,500.00	1,670,139,536.37	1,482,434,007.37	110,269,529.00
31	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	0.00	0.00	710,688,688.37	-710,688,688.37
310001	Улсын төсвөөс санхүүжих	0.00	0.00	751,132,388.37	-751,132,388.37
32	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	929,773,700.00	1,492,614,606.37	117,688,618.00	1,249,999,988.37
320001	Орон нутгийн төсвөөс	812,085,100.00	1,374,925,988.37	0.00	1,249,999,988.37
320002	Орон нутгийн хөгжлийн сангаас санхүүжих	117,688,600.00	117,688,618.00	117,688,618.00	0.00
35	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	982,663,800.00	177,524,930.00	654,056,701.00	-429,041,771.00
350001	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	238,410,000.00	153,553,930.00	153,553,930.00	0.00

Есөнзүйл сумын төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

350002	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	33,607,000.00	23,971,000.00	23,971,000.00	0.00
350003	Урьд оны үлдэгдлээс санхүүжих	710,646,800.00		750,828,532.69	-703,338,532.69
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	0.00	127,034,932.69	0.00	127,034,932.69
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	0.00	140,527,230.69	0.00	140,527,230.69

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

Код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	96,072,500.00	96,072,500.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	46,072,500.00	46,072,500.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	46,072,500.00	46,072,500.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	1,864,000.00	1,864,000.00
210303	Цэвэр, бохир ус	1,864,000.00	1,864,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	5,745,000.00	5,745,000.00
210604	Урсгал засвар	5,745,000.00	5,745,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	15,803,000.00	15,803,000.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	15,803,000.00	15,803,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	22,660,500.00	22,660,500.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	22,660,500.00	22,660,500.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	50,000,000.00	50,000,000.00
2200	Дотоод эх үүсвэрээр	50,000,000.00	50,000,000.00
223001	Бусад хөрөнгө	50,000,000.00	50,000,000.00
I	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	96,072,500.00	96,072,500.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	96,072,500.00	96,072,500.00
131103	ЗГНХ, ЗДН Хөрөнгө, түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	90,205,500.00	90,205,500.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	5,867,000.00	5,867,000.00

3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Сумын санхүүгийн алба нь Төсвийн тухай хуульд заасан чиг үүргийн дагуу төсөвт байгууллагуудын санхүүгийн үйл ажиллагааг удирдан зохион байгуулах, ажил гүйлгээг хянах, ажил гүйлгээг батлах чиг үүргийг гүйцэтгэдэг.

Санхүүгийн албанд дарга-1, мэргэжилтэн-1, нягтлан бодогч -3 нийт 5 орон тоотой ажиллаж байна. Тус суманд төсөвт байгууллага-6, орон нутгийн сан-3 үйл ажиллагаа явуулж байна.

3.2 Байгууллагын гадаад дотоод орчин

Төсвийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1. "Төсвийн ерөнхийлөн захирагч нь өөрийн удирдлага дор төсвийн шууд захирагчийг харьяалах эрх бүхий төсвийн төвлөрүүлэн захирагчтай байж болно." гэж заасан.

Мөн хуулийн 36.1. "Төрийн сангийн тогтолцоо нь төв төрийн сан, аймаг, нийслэлийн төрийн сан, сум, дүүргийн төрийн сан, төрийн захиргааны төв байгууллагын төрийн сангийн нэгж, төсвийн нягтлан бодогч /цаашид "төрийн сан" гэх/-оос бүрдэнэ.

36.2.Төв төрийн сан нь санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад, аймаг, нийслэл, сум, дүүргийн төрийн сан нь тухайн шатны Засаг даргын Тамгын газрын дэргэд байна.

36.3.Сум, дүүрэгт үйл ажиллагаа явуулж байгаа төсвийн байгууллагын үйл ажиллагааны чиглэл болон төсвийн хэмжээг нь харгалзан төрөлжүүлж, тэдгээрт хамаарах төсвийн байгууллагуудад нягтлан бодох бүртгэлийн үйлчилгээ үзүүлэх нэгдсэн алба байгуулж болно.” гэсэн заалтуудаар зохицуулагдаж байна.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Есөнзүйл сумын Төрийн сангийн 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлт

Есөнзүйл сумын төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайланг Сангийн сайдын 2015 оны 341 дүгээр тушаалаар баталсан “Төсвийн ерөнхийлөн захирагчийн болон Засгийн газрын санхүүгийн нэгтгэсэн тайлан, тодруулга бэлтгэх журам”-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 5,976.3 сая төгрөгөөр буурсан байна.

Хүснэгт 1. Санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлангийн үзүүлэлт

/сая төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	767.7	596.7	171.0
Авлага	266.0	382.7	-116.7
Бараа материал	293.3	52.4	240.9
Үндсэн хөрөнгө	7173.6	1492.4	5681.1
Нийт хөрөнгө	8500.6	2524.3	5976.3
Өр төлбөр	96.7	0.0	96.7
Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/	8403.9	2524.3	5879.6
Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн	8500.6	2524.3	5976.3

Тайлант онд сумын ОНХСанд 54.3 сая төгрөг, СХСанд 121.7 сая төгрөг, ЗДТГ 10.5 сая төгрөгийн авлага нэмэгдэж, ЭМТөвийн авлага 69.6 сая төгрөгөөр буурсан байна.

Бараа материалын үлдэгдэл 240.9 сая төгрөгөөр буурсан нь боловсрол, эрүүл мэнд, соёлын байгууллагуудын бараа материалын эхний үлдэгдлийг орон нутгийн өмчөөс төрийн өмчид шилжүүлсэнтэй холбоотой байна.

Үндсэн хөрөнгийн үлдэгдэл 5681.1 сая төгрөгөөр буурсан нь мөн боловсрол, эрүүл мэнд, соёлын байгууллагуудын үндсэн хөрөнгийн эхний үлдэгдлийг орон нутгийн өмчөөс төрийн өмчид шилжүүлсэнтэй холбоотой байна.

Өр төлбөр нь ЭМТөв, ЕБС-ийн өглөгөөр буурсан байна.

Мөнгөн хөрөнгө

Мөнгөн хөрөнгийн дансны эцсийн үлдэгдэл 596.7 сая төгрөг болж, өмнөх оноос 171.0 сая төгрөгөөр буурсан байна.

Хүснэгт 2. Мөнгөн хөрөнгийн үлдэгдэл

Үзүүлэлт	/сая төгрөгөөр/		
	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Кассад байгаа бэлэн мөнгө	0	0	
Банканд байгаа бэлэн мөнгө	767.7	596.7	171.0
Төгрөг			
Төрийн сангийн харилцах	767.7	596.7	171.0
Арилжааны банк дахь харилцах			
Дүн	767.7	596.7	171.0

Эх сурвалж: ТТЗ-ийн санхүүгийн нэгтгэсэн тайлан

Мөнгөн хөрөнгийн үлдэгдэл нь төрийн сангийн харилцах дансанд үлдэгдэлтэй байна. СХСан, ЭХСан ОНӨОрлого, ОНХСан зэрэг байгууллагууд мөнгөн хөрөнгийг үлдэгдэлтэй гарчээ.

3.4.2 Авлага

Авлага дансны эцсийн үлдэгдэл 382.7 сая төгрөг болж, өмнөх оноос 116.7 сая төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт 3. Авлагын үлдэгдэл

Үзүүлэлт	/сая төгрөгөөр/		
	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Ажиллагчтай холбогдсон авлага	0.1		0.1
Зээлийн хүүгийн авлага	3.3	27.7	-24.4
Байгууллагаас авах авлага	78.6	20.5	58.1
Хувь хүмүүсээс авах авлага	184.0	334.5	-150.5
Дүн	266.0	382.7	-116.7

Эх сурвалж: ТТЗ-ийн санхүүгийн нэгтгэсэн тайлан

Тайлант оны нийт авлагыг зээлийн хүүгийн авлага, байгууллагаас авах авлага, хувь хүмүүсээс авах авлага эзэлж байна.

3.4.3 Бараа материал

Бараа материалын дансны эцсийн үлдэгдэл 52.4 сая төгрөг болж, өмнөх оноос 240.9 сая төгрөгөөр буурсан байна.

Хүснэгт 4. Бараа материалын үлдэгдэл

Үзүүлэлт	/сая төгрөгөөр/		
	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Түүхий эд материал	88.6		88.6
Хангамжийн материал	198.8	52.4	146.4
Мал амьтад	5.9		5.9
Дүн	293.3	52.4	240.9

Эх сурвалж: ТТЗ-ийн санхүүгийн нэгтгэсэн тайлан

Бараа материалын үлдэгдэл 235.0 сая төгрөгөөр буурсан нь боловсрол, эрүүл мэнд, соёлын байгууллагуудын бараа материалын эхний үлдэгдлийг орон нутгийн өмчөөс төрийн өмчид шилжүүлсэн нь гол нөлөө үзүүлсэн байна.

3.4.4 Мал амьтад

Мал амьтад 5.9 сая төгрөгөөр буурсан байна.

3.4.5 Үндсэн хөрөнгө

Үндсэн хөрөнгийн дансны эцсийн үлдэгдэл цэвэр дүнгээр 1492.4 сая төгрөг болж, өмнөх оноос 5,681.1 сая төгрөгөөр буурсан байна.

Хүснэгт 6. Үндсэн хөрөнгийн үлдэгдэл

Үзүүлэлт	/сая төгрөгөөр/		
	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Биет хөрөнгө	7047.4	1409.5	5637.9
Барилга, байгууламж, орон сууц	6375.6	649.2	5726.4
Хуримтлагдсан элэгдэл	-592.1	-165.4	-426.7
Авто-тээврийн хэрэгсэл	340.0	275.7	64.2
Хуримтлагдсан элэгдэл	-190.0	-178.6	-11.4
Машин тоног төхөөрөмж(компьютер)	947.3	135.4	812.0
Хуримтлагдсан элэгдэл	-702.9	-54.2	-648.7
Тавилга, аж ахуйн эд хогшил	268.6	44.7	224.0
Хуримтлагдсан элэгдэл	-101.1	-24.6	-76.4
Бусад үндсэн хөрөнгө	818.1	955.1	-137.0
Хуримтлагдсан элэгдэл	-183.0	-227.8	44.8
Биет бус хөрөнгө	126.2	83.0	43.2
Программ хангамж	6.9	10.2	-3.3
Хуримтлагдсан элэгдэл	-3.9	-4.0	0.1
Бусад биет бус хөрөнгө	123.3	76.8	46.5
Дүн	7173.6	1492.4	5681.1

Эх сурвалж: ТТЗ-ийн санхүүгийн нэгтгэсэн тайлан

Үндсэн хөрөнгийн үлдэгдэл 5,681.1 сая төгрөгөөр буурсан нь боловсрол, эрүүл мэнд, соёлын байгууллагуудын үндсэн хөрөнгийн эхний үлдэгдлийг орон нутгийн өмчөөс төрийн өмчид шилжүүлсэнтэй холбоотой.

Сумын ЗДТГ, ИТХ зэрэг байгууллагууд Улсын болон орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар 74.6 сая төгрөгийн хөрөнгийг худалдан авч 146.9 сая төгрөгийн хөрөнгийг үнэ төлбөргүй хүлээн авч бүртгэлд тусгажээ.

3.4.6 Өр төлбөр

Нийт өр төлбөр 96.7 сая төгрөгөөр буурсан байна.

Хүснэгт 7. Нийт өр төлбөрийн үлдэгдэл

Үзүүлэлт	/сая төгрөгөөр/		
	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Ажилчидтай холбогдсон өглөг	9.2		9.2
Бараа үйлчилгээний зардлын өглөг	87.5		87.5
Дүн	96.7		96.7

Эх сурвалж: ТТЗ-ийн санхүүгийн нэгтгэсэн тайлан

Тайлант онд өр төлбөргүй гарчээ.

3.4.6 Засгийн газрын хувь оролцоо

Засгийн газрын хувь оролцоо дансны эцсийн үлдэгдэл 2524.3 сая төгрөг болж, өмнөх оноос 5879.6 сая төгрөгөөр буурсан байна.

Хүснэгт 8. Засгийн газрын хувь оролцоо

/ сая төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан			
Өмч /төрийн/ /ТӨҮГ/	2624.9	885.1	1739.7
Эздийн өмчийн бусад хэсэг /ТӨҮГ/			
Хуримтлагдсан үр дүн	4061.3	1269.6	2791.6
Өмнөх үеийн үр дүн	3790.9	7157.0	-3366.1
Тайлант үеийн үр дүн	270.4	-5887.3	6157.7
Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	1717.8	369.5	1348.3
Дүн	8403.9	2524.3	5879.6

Эх сурвалж: ТТЗ-ийн санхүүгийн нэгтгэсэн тайлан

Өмчийн дүн буурсан нь улсын төсвийн байгууллагуудын хөрөнгийн эхний үлдэгдлийг зардалд хааснаас тайлант оны үр дүн буурсантай холбоотой.

3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн шууд захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.5.1 Төсвийн төлөвлөлт

Сумын ИТХ-ын 2021 оны 06/02 тоот тогтоолоор 2022 оны төсвийн санхүүжүүлэх эх үүсвэрийг 1,996.6 сая төгрөгөөр баталжээ.

Сумын 2022 оны төсөвт тодотгол хийх тухай 2022 оны 09/01 тогтоолоор татварын буцаан олголтын дүнг 4.9 сая төгрөгөөр нэмэгдүүлж, аймгаас олгох санхүүгийн дэмжлэгийг 69.7 сая төгрөг, аймгийн орон нутгийн хөгжлийн сангаас олгох орлогын шилжүүлгийг 9.6 сая төгрөг, төсвийн ерөнхийлөн захирагч түүний харьяа зарим байгууллагын зардлыг 90.2 сая төгрөгөөр бууруулан баталсан байна.

3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Төвлөрүүлэх татварын болон татварын бус орлогын гүйцэтгэл 547.2 сая төгрөг буюу 175 хувиар давж биелжээ.

Хүснэгт-9

төгрөгөөр

Татварын орлого				
Орлогын төрөл	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
Үйл ажиллагааны орлого /ХХОАТ 8.1.1-с бусад	19,926,900	20,474,591.85	-547,691.9	102.7
ХХОАТ	119,189,700	135,800,310.18	-16,610,610.2	113.9
Бууны албан татвар	2,100,000	1,320,000	780,000.0	62.9
Улсын тэмдэгийн хураамж	1,000,000	717,760	282,240.0	71.8
Түгээмэл тархацтай ашигт малтмал ашигласны төлбөр	500,000		500,000.0	0.0
Хог хаягдлын хураамж	5,600,000	3,734,664	1,865,336.0	66.7
Хөрөнгийн орлого / хадгаламж	19,023,100	16,962,924	2,060,176.4	89.2
ан агнуурын орлого	15,498,700	356,055,600	-340,556,900.0	2297.3
Газрын төлбөр	3,430,100	2,545,448	884,652.0	74.2
ҮХХАТатвар	1,124,600	2,840,310	-1,715,710.0	252.6
Хөрөнгө борлуулсны орлого	716,700	2,108,100	-1,391,400.0	294.1
Татварын буцаалт	-9,242,200	-9,242,193	-6.8	100.0
Нийт дүн	178,867,600	533,317,514	-354,449,914	298
Татварын бус орлого				
хүү торгуул	19,769,700	13,837,500	5,932,200	70.0
НИЙТ ДҮН	198,637,300	547,155,014	-348,517,714	275

Татварын орлогын төлөвлөгөө нийт дүнгээр биелсэн ч бууны албан татвар, улсын тэмдэгтийн хураамж, түгээмэл тархацтай ашигт малтмал ашигласны төлбөр, хог хаягдлын хураамж, хөрөнгийн орлого, газрын төлбөр, хүү торгуулийн орлого биелэгдээгүй байна.

ХХОАТ, үйл ажиллагааны орлого, ҮХХАТатвар, хөрөнгө борлуулсны орлого давсан байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Нэмэлт төсвийн дансаар 96.0 сая төгрөгийн санхүүжилт авч, бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж, хөрөнгийн зардал, бараа үйлчилгээний зардалд зарцуулжээ.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

3.5.4 Төсөл хөтөлбөрийн үе шат, хүрэх үр дүн

Хэрэгжүүлэхээр төлөвлөсөн төсөл хөтөлбөр байхгүй байна.

4. АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Есөнзүйл сумын төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав. Мөн байгууллагын үйл ажиллагааг сайжруулахтай холбоотой өгсөн зөвлөмжийг тусгасан болно.

Аудитыг Төрийн аудитын газрын аудитор Ц.Мөнхзаяа гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер Д.Гансүх, газрын захирал, тэргүүлэх аудитор О.Батжаргал нар тус тус хэрэгжүүлсэн.

Есөнзүйл сумын ТТЗ-ийн 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг Өвөрхангай аймаг дахь Төрийн аудитын газарт 2023 оны 03 дугаар сарын 02-ны өдрийн 1/17 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт зардлын дүнг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг 75 хувь гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2022 оны нийт зардлын дүн 1399.8 сая төгрөгөөс 1 хувиар буюу 13.9 сая төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбоотойгоор суманд олгох санхүүгийн дэмжлэг буурч, төсөвтөө хасах тодотгол хийсэн ба тэр хэмжээгээр холбогдох зардлууд хэмнэгдсэн байна.

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан "Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам"-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Есөнзүйл сумын ТТЗ нь 2022 онд 155 мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст байршуулахаас 154 мэдээллийг ил тод мэдээлсэн, 1 мэдээллийн хугацаа болоогүй байна.

Шилэн дансны тухай хуулийг хэрэгжүүлж ажилласан байна.

4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Тус байгууллагын хувьд бусад нийцлийн асуудлын талаарх хамааралтай асуудал байхгүй байна.

4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

4.5.1 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх оны аудитаар ТТЗ-тай холбоотой зөрчил илрээгүй.

Хүснэгт 10. Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Өмнөх аудитаар		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Акт					
Албан шаардлага					
Зөвлөмж					
Нийт дүн					

4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Төсвийг үр ашигтай хэмнэлттэй зарцуулж, тухайн байгууллагын үндсэн үйл ажиллагааны зардлаас бусад зардалд төсвийн хөрөнгийг зарцуулахгүй байх

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар 2 зөрчил¹ илэрч, 1 албан шаардлага, 1 зөвлөмж өгсөн.

нзү¹ Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

5.1 Төлбөрийн акт

Тус байгууллага дээр акт гараагүй.

5.2 Албан шаардлага

Нягтлан бодох бүртгэлийн тогтолцоотой холбоотой асуудал

Илрүүлэлт:

Эрсдэлээс хамгаалах сангаас худалдан авсан мотоциклийг ЗДТГ-ын хөрөнгөнд бүртгээгүй байна

Шийдвэрлэлт:

Мотоциклийг ЗДТГ-ын хөрөнгөнд бүртгэн зөрчлийг таслан зогсоох албан шаардлага хүргүүлсэн.

5.3 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Шийдвэр гаргалт, үйл ажиллагаатай холбоотой асуудал

Илрүүлэлт:

Сумдын төсөвт байгууллагуудын дарга нарт ур чадварын нэмэгдэл олгохдоо ажлын үр дүнтэй уялдуулж хувь хэмжээг тогтоож, тухай бүр шийдвэр гаргаагүй, бүтэн жилээр тогтмол олгож ирсэн байна.

Өгсөн зөвлөмж:

Байгууллагын удирдлагуудын ур чадварын нэмэгдлийг улирал тутам ажлын үр дүнгийн үзүүлэлттэй уялдуулан тухай бүр тогтоож олгох.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2023 оны 6 дугаар сарын 01-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

ТТЗ-ийн харьяа байгууллагуудад илэрсэн зөрчлийн талаар

Аудитад хамрагдсан 4 байгууллага түүвэрт хамруулсан./ ЗДТГ, ИТХ, ОНХСан, СХСан/

Харьяа байгууллагуудын зөрчлийн нэгтгэлээр 34.7 сая төгрөгийн алдаа зөрчил илэрч 4 албан шаардлага, 2 зөвлөмж хүргүүлсэн байна.

- ЗДТГазар- Сумын Засаг даргын нөөцөөс хөшөө хийлгэх зардалд 6200.0 мянган төгрөг зарцуулсан байна.
- ИТХ- Байгууллага нь бараа материалыг орлогод авах, зарцуулах буюу байгууллагын хэрэгцээнд тавьж олгохдоо бараа материалын байнгын системээр бүртгээгүй, бөөн дүнгээр бүртгэсэн.
- Байгууллага нь 2021 оны жилийн эцсийн 1700.0 мянган төгрөгийн өглөгийн үлдэгдлийг тооцоо нийлсэн акт, бусад баримтаар баталгаажуулаагүй. Хүчин төгөлдөр бус баримтаар тайлант онд ажил гүйлгээг бүртгэсэн нь авлага, өглөгийг нягтлан бодох бүртгэлд тусгахгүй орхигдуулах, санхүүгийн тайлан буруу илэрхийлэгдэх эрсдэл байна.
- СХСан- Хоршоо хөгжүүлэх сангаас олгосон хүүгийн өмнөх жилийн орлогоос 2274.0 мянган төгрөгийг холбогдох журмын дагуу зарцуулаагүй
- Эрсдэлээс хамгаалах сан- Эрсдэлээс хамгаалах сангаас худалдан авсан мотоциклийг ЗДТГ-ын хөрөнгөнд бүртгээгүй байна

- Төрийн сан- Сумдын төсөвт байгууллагуудын дарга нарт ур чадварын нэмэгдэл олгохдоо ажлын үр дүнтэй уялдуулж хувь хэмжээг тогтоож, тухай бүр шийдвэр гаргаагүй, бүтэн жилээр тогтмол олгож ирсэн зөрчлүүд илэрсэн байна.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/сая төгрөгөөр/

Байгууллагын нэр	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Залруулсан		Залруулаагүй		Тоо	Дүн
							Тоо	Дүн	Тоо	Дүн		
Дүн												

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/сая төгрөгөөр/

Байгууллагын нэр	Нийт зөрчил		Үүнээс									
	Тоо	Дүн	Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
			Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо
Есөнзүйл ТТЗ	2	0			1		1	0				
Дүн	2				1		1					

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/сая төгрөгөөр/

Байгууллагын нэр	Нийт зөрчил		Үүнээс					
	Тоо	Дүн	Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
			Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил								
Дүн								
Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил								
Дүн								
Нийт дүн								



ӨВӨРХАНГАЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

2023 ОНЫ 03 ДУГААР САРЫН 25-НИЙ ӨДӨР